

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Тохилог хараа" ААТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/17-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: Baasanurens@audit.gov.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2022/17-НА-СТА-ОНА

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3-5
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6-7
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9-10
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12-13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13-14
3.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14-15
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Дотод хяналт	15-16
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
4.4 Материаллаг байдал	16-17
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17-18
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
8. Аудитын илрүүлэлт	18
8.1 Залруулсан алдаа.....	18-19
8.2 Албан шаардлага	19-20
8.3 Зөвлөмж	20-22
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22-26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч



“ТОХИЛОГ ХАРАА” ААТҮГ-ЫН
ДАРГА Э.БАЯРХҮҮ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

Цагаан Эрэг II баг

Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040

E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/17-НА-СТА-ОНА.

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тохиллог хараа” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Тохиллог хараа” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг зохистой удирдаагүй, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, бодлого менежментийг зөв тогтоогоогүйгээс тайлант онд **184,669.5** мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдан, өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байна,
- Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулж, мөрдөж ажиллаагүй,
- Тайлант онд бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, зарлагын баримт, ажил гүйцэтгүүлэх гэрээ, мөнгө хүссэн өргөдөл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт 10,478.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг хийж, бүртгэл тайланд тусгасан,
- Сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/07 дугаар захирамжаар үйлдвэрийн газрын даргыг томилж, бүтцийн өөрчлөлт хийсэн

СЭА-2022/17-НА-СТА-ОНА

3

018020364

байхад үйлдвэрийн газрын ажиллагсдыг төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээгээр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-10 хувиар тогтоож 4,196.3 мянган төгрөг, ур чадварын нэмэгдлийг 5-20 хувиар тогтоож 5,504.4 мянган төгрөг зэрэг нийт **9,700.7** мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон,

- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн ажиллагсад 2, 3, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд нийт 11,331.8 мянган төгрөгийг олгосон байна.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр **өөрийгөө санхүүжүүлэх** зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.*”, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгахыг хориглоно*”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “*Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам*”, 4 дүгээр хавсралтаар баталсан “*Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам*”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “*Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам*”-ын холбогдох заалтууд болон Мандал сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор баталсан “*Үйлдвэрийн газрын дүрэм*”-ийн 7.3 дахь “*Тохилог хараа үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо, цалин хөлсний норм нормативыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоох ба ...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Бусад мэдээлэл

Тайлант онд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	4,068,627.15
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	3,704,950.36
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	-	32,660,490.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10		-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	40,434,067.51
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	23,462,590,186.81
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	23,462,590,186.81
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9		-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	23,462,590,186.81
1.3	Нийт хөрөнгийн дүн	-	23,503,024,254.32
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	-	31,393,802.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	-
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12		-	-

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Тохилог хараа ААТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	31,393,802.00
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-4347143093
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	54210265.905
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5		-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	31,393,802.00
	ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.3	Өмч	-	1,014,238,197.67
2.3.1	-төрийн	-	1,014,238,197.67
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	1,547,846.88
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	21,541,821,242.28
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	914,023,165.49
2.3.10		-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	-	23,471,630,452.32
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	-	23,503,024,254.32

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	530,397,896.00
2	Борлуулалтын өртөг	-	
3	Нийт ашиг (алдагдал)	-	
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	63,988,734.23
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	651,078,636.62
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	(184,669,474.85)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	(184,669,474.85)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(184,669,474.85)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	1,014,238,197.67	1,547,846.88	-	1,098,692,581.12	2,114,478,625.67
3	Залруулсан үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	-	1,098,692,581.12	2,114,478,625.67
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	21,541,821,242.28	(184,669,474.85)	21,357,151,767.43
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	21,541,821,242.28	914,023,165.49	23,471,630,393.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	-	530,397,896.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	24,330,496.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	506,067,400.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	-	526,329,255.72
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	204,383,628.12
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	32,200,475.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	72,099,600.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	63,237,468.77
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	83,754,857.30
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	562,000.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Тохилог хараа ААТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	462,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	69,629,225.58
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	4,068,627.15
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8		-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6		-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4		-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5		-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	4,068,627.15
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	-	-
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	4,068,627.15

2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	төгрөг	-	-	530,397,896.00	-	-
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төгрөг	-	-	530,397,896.00	-	-
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	төгрөг	-	-	-	-	-
3	Нийт зардал		-	-	715,067,370.85	-	-
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	төгрөг	-	-	-	-	-
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	төгрөг	-	-	63,988,734.23	-	-
	в) Хөрөнгө оруулалт их засвар-Бусад зардал	төгрөг	-	-	651,078,636.62	-	-
4	Цэвэр ашиг, алдагдал	төгрөг	-	-	(184,669,474.85)	-	-

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог хараа” ААТҮГ / цаашид Тохилог хараа ААТҮГ гэх/ нь “ Мандал сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг хангаж, өнгө төрхийг орчин үеийн хөгжлийн шинэ түвшинд хүргэх, ногоон байгууламжаа нэмэгдүүлж, байгальд ээлтэй иргэдтэй, хог хаягдлаа ангилдаг ногоон сум болгох.” гэсэн эрхэм зорилготойгоор тайлант онд үйл ажиллагаа явуулсан байна.

“Тохилог хараа” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто замын хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх,
- Сумын төвийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зөөж тээвэрлэх,
- Сумын төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа,
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт үйлчилгээ,
- Авто зам болон нийтийн эдэлбэр газрын гэрэлтүүлгийн ашиглалт, засвар үйлчилгээ,
- Гадаад, дотоод худалдаа эрхлэх,
- Авто тээвэр, бусад төрлийн машин механизмаар төлбөртэй үйлчлэх,
- Өөрийн эзэмшлийн хөрөнгө болон ажил үйлчилгээг бусдад түрээсээр ашиглуулах,
- Үйл ажиллагааны чиглэлд орсон өөрчлөлтүүдийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Мандал сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор “Тохилог хараа” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулж, 1 дүгээр хавсралтаар үйлдвэрийн газрын дүрмийг, 2 дугаар хавсралтаар үйл ажиллагааны төлөвлөгөөг, 3 дугаар хавсралтаар төсөв, санхүүг тус тус баталсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын ж-д “ Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай тус тус нийцэж байна.

Тус үйлдвэрийн газар нь 2020 онд Мандал сумын “Хот тохижуулах газар” төсөвт байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд тус сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/07 дугаар захирамжаар “Тохилог хараа” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Э.Баярхүүг томилсноор улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга, тэмдгийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчилсөн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “*Даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна.*” гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын 1-д “*Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх*”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “*Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай*”,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “*ТБОНӨХБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай*” гэх мэт.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар гаргаж ирүүлснийг аудитын явцад аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн батлагдсан маягтаар тайлагнуулж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Энгийн төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	4,068.6	
Авлага	-	3,704.9	
Бараа материал	-	32,660.5	
Үндсэн хөрөнгө	-	23,462,590.2	
Нийт хөрөнгө	-	23,503,024.2	
Өр төлбөр	-	31,393.8	
Эздийн өмч		1,014,238.1	

**Сэлэнгэ аймгийн Мандал сумын Тохилог хараа ААТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		1,547.8	
Эздийн өмчийн бусад хэсэг		21,541,821.4	
Хуримтлагдсан ашиг /+/ , алдагдал /-/	-	914,023.1	
Нийт өр төлбөр ба эздийн өмч /цэвэр хөрөнгө өмч/-ийн дүн	-	23,503,024.2	

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 4,068.6 мянган төгрөг нь нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто замын хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэхэд орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн үлдэгдэл байна.

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлсэн 3,704.9 мянган төгрөгийг авлага дансанд тайлагнасан байна.

Тайлант онд 15,240.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 166,939.9 мянган төгрөгийн бараа материалыг Хот тохижуулах газраас үнэ төлбөргүйгээр хүлээн аван, 149,519.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 32,660.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тайлант онд өөрийн хөрөнгөөр нийт 63,050.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан бол Хот тохижуулах газраас 3,268,792.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, аймгийн ОНӨГ-ын 2021 оны 255 дугаар албан бичгийн дагуу 20,681,907.1 мянган төгрөгийн өртөг бүхий УБ-Дархан чиглэлийн авто замаас Мандал сум хүртэлх 28.7 км хатуу хучилттай авто зам, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 747,447.4 мянган төгрөгийн өртөг бүхий гудамж талбайн гэрэлтүүлэг, аймгийн ИТХТ-ийн 2021 оны 123 дугаар тогтоолоор Мандал Энержо ОНӨААТҮГ-аас 184,450.0 мянган төгрөгийн машин механизм, Мандал сумын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 40,815.2 мянган төгрөгийн өртөг бүхий албан конторын барилга, сумын ЗДТГ-аас 10,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий түрэгч трактор зэрэг нийт 21,664,619.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, тайлагнасан байна.

Тайлант онд гудамж, талбайн гэрэлтүүлгийн гэрлийн толгой худалдаж авсан төлбөрийн үлдэгдэл 24,999.9 мянган төгрөг, албан конторын халаалтын төлбөр 3,195.3 мянган төгрөг, усны төлбөр 3,198.6 мянган төгрөг зэрэг нийт 31,393.8 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлагнасан байна.

Хот тохижуулах газрын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаас шилжүүлэн бүртгэсэн эздийн өмч 1,014,238.1 мянган төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 1,547.8 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг 914,023.1 мянган төгрөгийг тайлагнасан бол 21,541,821.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт тайлагнасан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Тохилог хараа” ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн

төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Тохилог хараа” ААТҮГ нь 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй бөгөөд гүйцэтгэлээр 530,397.8 мянган төгрөг /төсвийн төвлөрүүлэн захирагчаас олгосон санхүүжилт 506,067.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 24,330.4 мянган төгрөг/-ийн орлого бүрдүүлж, 715,067.3 мянган төгрөгийн зардал гарган, 184,669.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тохилог хараа ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэх, аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн жишиг заавар”-ыг мөрдөж ажиллах, жолоочийн тооцооны хуудаст холбогдох үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэт бүртгэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын эзэмшилд шилжүүлэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тохилог хараа ААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай гэж дүгнэж байна. Үүнд:

- 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо, зохион байгуулалт, цалингийн болон бусад зардлыг төлөвлөж, холбогдох байгууллагаар батлуулаагүй,
- Аймгийн ТЕЗ-аас баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй,
- Үйлдвэрийн газрын дотоод журмыг боловсруулж, мөрдөж ажиллаагүй,
- Үйлдвэрийн газрын тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнг холбогдох байгууллагад танилцуулж, үнэлэлт дүгнэлт өгөгдөөгүй байна.

“Тохилог хараа” ААТҮГ нь аймгийн ТЕЗ-ийн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж, нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүй учир цаашид дээрх бодлогын бичиг баримтыг мөрдөх, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналыг НББОУС-д нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус үйлдвэрийн газрын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь өөрчилж, сайжруулах шаардлагатай байна гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тохилог хараа ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “**дунд**” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогын 530,397.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу

7,955.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 5,966.9 мянган төгрөгөөр тогтоов.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант онд "Тохилог хараа" ААТҮГ нь Шилэн дансны цахим хуудаст шинээр цэс нээлгэсэн бөгөөд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.4 дэх заалтуудыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Мандал сумын Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн Б/28 дугаар захирамжаар тус үйлдвэрийн газрын даргын цалинг 18.5 хувиар, үйлдвэрийн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 80 дугаар тушаалаар ажиллагсдын цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, **цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх**" гэж заасантай нийцэхгүй байна.

2.Тайлант онд нийт 5,239.8 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 2,650.0 мянган төгрөгийн үнэ бүхий конторын тавилга, ажиллагсдад 2,295.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас, **3,500.0** мянган төгрөгийн үнэтэй Зил-130 автомашин зэрэг шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоол болон удирдах бусад байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тус газар нь төсвийн байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан тул Мандал сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар түүвэрт хамрагдсан бөгөөд зөвлөмж өгөөгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Тайлант онд байгууллагын дотоод журмыг баталж, мөрдөөгүй байгаа нь үйлдвэрийн газрын дүрмийн 7.4-т “Захирал дараах эрх үүрэгтэй:” “7.4.2.Үйлдвэрийн газрын дотоод журмыг баталж мөрдүүлэх” гэж заасантай нийцэхгүй байгаа тул цаашид байгууллагын дотоод журмыг боловсруулж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 575,167.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 330,988.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 216,180.6 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 27,998.5 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгөв.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 330,988.2 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Тайлант онд худалдан авсан нийт 9,890.0 мянган төгрөгийн үнэ бүхий Зил-130 машины 23 ширхэг дугуй, 1,361.5 мянган төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг вакуум цонхыг үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэж, тайлагнасныг бараа материалд шилжүүлэн бүртгүүлэв.
- Улсын комиссын актаар хүлээн авч, ашиглалтад оруулаагүй 319,736.7 мянган төгрөгийн өртөг бүхий “Мандал сумын 3 дугаар багийн тоглоомын талбай”-г эрх бүхий байгууллага болох аймгийн ОНӨГ-ын зөвшөөрөлгүйгээр үндсэн

хөрөнгийн дуусаагүй барилга байгууламжид бүртгэж, тайлагнасныг
залруулав.

8.2 Албан шаардлага

1. Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулж, мөрдөж ажиллаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “**Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах**” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, мөрдөх албан шаардлага хүргүүлэх.

2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг зохистой удирдаагүй, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, бодлого менежментийг зөв тогтоогоогүйгээс тайлант онд **184,669.5** мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдан, өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “**Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.**” гэсэн тодорхойлолтыг хангаж чадахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, бодлого менежментийг зөв тогтоох замаар үйлдвэрлэлийн үр дүнгээр ашиг хүлээж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3. Сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/07 дугаар захирамжаар үйлдвэрийн газрын даргыг томилж, бүтцийн өөрчлөлт хийсэн байхад үйлдвэрийн газрын ажиллагсдыг төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээгээр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-10 хувиар тогтоож 4,196.3 мянган төгрөг, ур чадварын нэмэгдлийг 5-20 хувиар тогтоож 5,504.4 мянган төгрөг зэрэг нийт **9,700.7** мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “*Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам*”, “*Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам*” болон сумын ИТХ-ын 2019 оны 90 дүгээр тогтоолоор баталсан “*Үйлдвэрийн газрын дүрэм*”-ийн 7.3 дахь “*Тохилог хараа үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо, цалин хөлсний норм нормативыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоох ...*” гэсэн заалтуудтай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын дүрэмд заасны дагуу орон тоо, цалин, хөлсийг сумын ИТХ-аар тогтоолгож, батлуулах албан шаардлага хүргүүлэх.

4. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.5 дахь “Энэ журмын 2.4-т зааснаас бусад **төрийн албан хаагчид** үр дүнгийн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно.” гэсэн заалтыг үндэслэн үйлдвэрийн ажиллагсад 2, 3, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд нийт 11,331.8 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь дээрх журмын холбогдох заалтуудтай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсадтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон үйлдвэрийн газрын дотоод журамд шагнал, урамшууллын асуудлыг тусгаж, улирлын ажлын үр дүнг үнэлсний үндсэн дээр урамшуулал олгож байх албан шаардлага хүргүүлэх.

5. Тайлант онд бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, зарлагын баримт, ажил гүйцэтгүүлэх гэрээ, мөнгө хүссэн өргөдөл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт 10,478.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүү нягтлан бодох бүртгэлийн программтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж, ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ..., мөрдөж ажиллана.” гэж заасантай нийцээгүй бөгөөд

санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, аж ахуйн газрын программ ашиглах.

2. Хөрөнгийн эзэмшилтэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт: Одоо ашиглагдаж байгаа 80,000.0 мянган төгрөгийн анхны үнэтэй Хьюндай маркийн 7202 ТӨА улсын дугаартай зам шүүрдэгч, 8,550.0 мянган төгрөгийн анхны үнэтэй Мицубиши кантер маркийн 1605 СЭА улсын дугаартай ачааны, 7,000.0 мянган төгрөгийн анхны үнэтэй Зил-4505 маркийн 4981 СЭҮ улсын дугаартай ачааны, 2,058.5 мянган төгрөгийн анхны үнэтэй Зил-130 маркийн усны машинуудын тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь тус үйлдвэрийн газрын эзэмшилд бүртгэгдээгүй байна. Энэ нь Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 3.2-т “Өмчлөгч нь энэ журмын 3.1-д заасан шилжилт, хөдөлгөөнийг 7 хоногийн дотор хийлгэх үүрэгтэй.”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (а)-д тодорхойлсон заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх машинуудын тээврийн хэрэгслийн гэрчилгээг 2022 оны 2 дугаар улиралд багтаан байгууллагын эзэмшилд шилжүүлэх.

3. Анхан шатны болон төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 27,998.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх.

3.2.1. Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудаст спидометрийн эхний, эцсийн заалт бичигдээгүй байна.

3.2.2. Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус зөрчсөн тул цаашид жолоочийн тооцооны хуудаст холбогдох үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэт бүртгэх, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

		/мянган төгрөгөөр/									
Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс					
						Залруулга		Акт		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар											
1	"Тохилог хараа" ААТҮГ	СЭА-2022/17-НА-СТА-ОНА	Тайлант онд худалдан авсан нийт 9,890.0 мянган төгрөгийн үнэ бүхий Зил-130 машины 23 ширхэг дугуй, 1,361.5 мянган төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг вакуум цонхыг үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэж, тайлагнасан.	1	11,251.5	1	11,251.5				
2	"Тохилог хараа" ААТҮГ	СЭА-2022/17-НА-СТА-ОНА	Улсын комиссын актаар хүлээн авч, ашиглалтад оруулаагүй 319,736.7 мянган төгрөгийн өртөг бүхий "Мандал сумын 3 дугаар багийн тоглоомын талбай"-г аймгийн ОНӨГ-ын зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга байгууламжид бүртгэж, тайлагнасан.	1	319,736.7	1	319,736.7				

3	"Тохилог хараа" ААТҮГ	СЭА-2022/17-НА-СТА-ОНА	Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулж, мөрдөж ажиллаагүй.	1	-							1	-				
4	"Тохилог хараа" ААТҮГ	СЭА-2022/17-НА-СТА-ОНА	Өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахгүй, үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээсэн.	1	184,669.5							1	184,669.5				
5	"Тохилог хараа" ААТҮГ	СЭА-2022/17-НА-СТА-ОНА	Ажиллагсдад төрийн алба хаасан хугацааны болон чадварын ур нэмэгдэл олгосон.	1	9,700.7							1	9,700.7				
6	"Тохилог хараа" ААТҮГ	СЭА-2022/17-НА-СТА-ОНА	Төрийн албан хаагчдад улирлын ажлын мөнгөн урамшуулал олгох журмын дагуу ажиллагсдад улирлын ажлын урамшуулал олгосон	1	11,331.8							1	11,331.8				
7	"Тохилог хараа" ААТҮГ	СЭА-2022/17-НА-СТА-ОНА	Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг хийж, бүртгэл тайланд тусгасан.	1	10,478.6							1	10,478.6				
8	"Тохилог хараа" ААТҮГ	СЭА-2022/17-НА-СТА-ОНА	Аймгийн ТЭЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн	1												1	-

			бодлогын баримт бичиг"-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж, ажиллаагүй.																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																								
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

